

ГАДААД АЖИЛТАНД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэн /цаашид “ажил олгогч” гэх/-тэй хөдөлмөрийн гэрээгээр ажиллах гадаад ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох үйлчилгээтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Гадаад ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох үйлчилгээг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т заасан байгууллага /цаашид 'эрх бүхий байгууллага' гэх/ эрхлэнэ. Үүнд:

- 1.2.1. Гадаад ажилтныг хөдөлмөр эрхлүүлэхээр урих,
- 1.2.2. Гадаад ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох
- 1.2.3. Гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгах
- 1.2.4. Гадаад ажилтныг шилжүүлэн хөдөлмөр эрхлүүлэх
- 1.2.5. Гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох
- 1.2.6. Ажил олгогчийн гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрлийг цуцлах
- 1.2.7. Гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бусад

Хоёр. Гадаад улсаас ажилтан авч ажиллуулах хүсэлт гаргах

2.1. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 –т заасан эрх үүссэн ажил олгогч гадаад улсаас ажилтан авч ажиллуулах хүсэлтээ уг хуулийн 23.5-д заасны дагуу дараах баримт бичгийн хамт эрх бүхий байгууллагад цаасаар болон цахим хэлбэрээр гаргана.

- 2.1.1 Гадаад ажилтан ажиллуулах ажлын байрны ангилал, төрөл, жагсаалт, байршил, тэдгээрийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон ажлын төлөвлөгөө
- 2.1.2 Улсын бүртгэлийн гэрчилгээ, зөвшөөрөлтэй эрхлэх ажил, үйлчилгээнд хамаарах бол зөвшөөрөл
- 2.1.3 Гадаад ажилтны мэргэжил ур чадварыг нотолсон баримт бичиг /тухайн улсын хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар баталгаажсан байх
- 2.1.4 Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 23.4-т заасан шаардлагыг хангасан талаарх мэдээлэл
- 2.1.5 Үйлчилгээний хураамж төлсөн баримт
- 2.1.6 Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт
- 2.1.7 Хууль тогтоомжид заасан бусад

- 2.2 Эрх бүхий байгууллага нь ажил олгогчийн хүсэлтийг хүлээн авсанаас хойш ажлын 5 хоногт багтаан гадаад ажилтан урих зөвшөөрлийг гурван сарын хугацаагаар олгоно.
- 2.3 Ажил олгогчийн бүрдүүлсэн материал энэхүү журмын 2.1-д заасан бүрдэлийг хангаагүй тохиолдолд хүлээн авахгүй.

2.4. Ажил олгогч заасан хугацаанд гадаад ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулж, гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл аваагүй нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол дээрх хугацааг нэг удаа гурав хүртэл сараар сунгана.

2.5. Эрх бүхий байгууллага ажил олгогчид гадаад улсаас ажилтан урих зөвшөөрөл олгоход Засгийн газраас баталсан гадаад ажилтны тоо, хувь хэмжээг баримтална

Гурав. Гадаад ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах

3.1. Энэхүү журмын 2.2 дахь хэсэгт заасан зөвшөөрөл авсан ажил олгогч болон гадаад ажилтныг шилжүүлэн ажиллуулах хүсэлтэй байгаа ажил олгогч гадаад ажилтныг сонгон хөдөлмөрийн гэрээ байгуулж, дараах баримт бичгийн хамт эрх бүхий байгууллагад хүргүүлнэ:

3.1.1 Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл хүссэн албан бичиг

3.1.2 Ажлын байрны төлбөр төлсөн баримт

3.1.3 Эрүүл мэнд болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан маягтын дагуу эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан баримт

3.1.4 Гадаад ажилтны паспортын хуулбар, Монгол Улсын хилээр нэвтэрсэн тэмдэглэгээ бүхий хуудсын хамт

3.1.5 Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 5.1.53 дахь заалтад заасан хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгохтой холбоотой үйлчилгээний хураамж төлсөн баримт.

3.1.6 Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөгдсөн тохиолдолд 3.1.2-д заасан баримтыг шаардахгүй.

3.2. Эрх бүхийн байгууллага ажил олгогчоос ирүүлсэн мэдээллийг хянан үзсэний үндсэн дээр ажлын 3 хоногт багтаан гадаад ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгоно.

3.3 Ажил олгогчийн бүрдүүлсэн материал энэхүү журмын 3.1-д заасан бүрдэлийг хангаагүй тохиолдолд хүлээн авахгүй.

3.4. Энэ журмын 3.2-т заасан шаардлагыг хангасан байгууллагын гадаад ажилтанд түүний овог нэр, иргэний харьяалал, хөдөлмөр эрхлүүлэх хуулийн этгээдийн нэр, хөдөлмөр эрхлэх байршил, зөвшөөрлийн хугацаа зэрэг мэдээллийг агуулсан зөвшөөрлийн үнэмлэхийг олгоно.

3.5. Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг ажлын байр, хөдөлмөрийн гэрээний хугацаанаас хамааруулан нэг жил хүртэл хугацаагаар олгоно.

3.6. Гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацааг ажил олгогчийн хүсэлт, ажлын гүйцэтгэл, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны ангилал, цаашид ажиллуулах болсон үндэслэл, хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг үндэслэн нэг жилээс илүүгүй хугацаагаар сунгаж болно.

3.7. Туслах албан тушаалын ажлын байранд ажиллаж байгаа гадаад ажилтан Монгол Улсад тасралтгүй хөдөлмөр эрхлэх нийт хугацаа тав хүртэл жил байна.

Дөрөв. Гадаад ажилтныг шилжүүлэн ажиллуулах

4.1. Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл бүхий ажил олгогч, гадаад ажилтан Ажиллах хүчний шилжих хөдөлгөөний тухай хуулийн 29.1.1-29.1.5 –д заасан тохиолдолд өөр байгууллагад шилжих хөдөлмөр эрхлэх хүсэлтээ хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргаж болно.

4.1.1 Хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд Улсын бүртгэлийн байгууллагын хуулийн этгээд татан буугдсан тухай нотлох бичиг баримт

4.1.2 Хугацаанаас өмнө гэрээт ажлаа хийж гүйцэтгэсэн, гэрээт ажил ажилтнаас шалтгаалахгүйгээр зогссон, ажилтнаас үл хамаарах шалтгаанаар хөдөлмөрийн гэрээг цуцлах тухай мэдэгдэл авсан тохиолдолд тэдгээрийг нотлох ажил олгогчийн тодорхойлолт

4.1.3 Ажил олгогч нь хөдөлмөрийн гэрээг зөрчсөн тохиолдолд түүнийг нотлох эрх бүхий байгууллагын шийдвэр

4.2. Гадаад ажилтан өөр байгууллагад шилжих тохиолдолд анх олгосон хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацаанд багтаан хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгоно.

4.3. Гадаад ажилтны шилжин хөдөлмөр эрхлэх ажил олгогч энэ журмын 3.1 д заасан хангасан баримт бичгийг бүрдүүлэн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.4. Эрх бүхийн байгууллага ажил олгогчоос ирүүлсэн мэдээллийг хянан үзсэний үндсэн дээр ажлын 3 хоногт багтаан шилжин хөдөлмөр эрхлэх гадаад ажилтанд зөвшөөрөл олгоно.

4.5. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүсэлт гаргасан гадаад ажилтныг өөр ажил олгогчид шилжүүлэн хөдөлмөр эрхлүүлэх боломжгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд ажил олгогч нь холбогдох хуульд заасан хугацаанд гадаад ажилтныг Монгол Улсын хилээр гаргаж, энэ тухай мэдэгдэнэ.

Тав. Гадаад ажилтныг урих зөвшөөрлийг хязгаарлах, Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох

5.1. Эрх бүхий байгууллага нь дараах тохиолдолд ажил олгогчийн гадаад ажилтныг урих эрхийг хоёр жилийн хугацаанд хязгаарлана.

5.1.1. Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлгүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнээр хөдөлмөр эрхлүүлсэн;

5.1.2. Өмнө нь хөдөлмөр эрхлүүлж байсан гадаад ажилтны цалин хөлсийг олгоогүй, эсхүл хохирол учруулсан нь тогтоогдсон;

5.1.3. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 22.4, 23.3, 23.4, 23.5.4-т заасан үүргээ биелүүлээгүй, тайлан мэдээг хуурамчаар гаргасан нь тогтоогдсон;

5.1.4. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1.1, 10.1.3-т заасан үүргээ биелүүлээгүй нь тогтоогдсон;

5.1.5. энэ хуулийн 26.1-д заасны дагуу зөвшөөрлөө цуцлуулсан.

5.2. эрх бүхий байгууллага дараах үндэслэлээр ажил олгогчийн гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрлийг цуцална:

5.2.1. зөвшөөрөл олгосон шийдвэр нь хууль бус болохыг эрх бүхий байгууллага тогтоосон бол;

5.2.2. тухайн ажлыг гүйцэтгэхэд зохих мэргэжил, ур чадварын шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг хөдөлмөр эрхлүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан нь тогтоогдсон бол;

5.2.3. гадаад ажилтныг хилээр орж ирэхээс өмнө байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр тохирсон цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөл, ажил, амралтын горим зэрэг гэрээний нөхцөлийг хангаагүй нь тогтоогдсон бол;

5.2.4. ажил олгогч хөдөлмөрийн хууль тогтоомж болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдож гадаад ажилтнаар Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэх боломжгүй болсон бол;

5.2.5. гадаад ажилтныг хөдөлмөрт бэлтгэх сургалт, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулаагүй, гадаад ажилтны хувийн баримт бичиг, цалин хөлсийг барьцаалсан бол;

5.2.6. гадаад ажилтныг хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрөл авснаас өөр зорилго, байршилд ажил үүрэг гүйцэтгүүлсэн, хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрөл авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн бол.

5.3. Эрх бүхий байгууллага дараах тохиолдолд гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох

5.3.1. гадаад ажилтны буруугаас хөдөлмөрийн гэрээг цуцалсан нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон, эсхүл хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон бол;

5.3.2. эрүүл мэндийн үзлэг, шинжилгээгээр тухайн ажлыг гүйцэтгэхэд эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй болсон нь тогтоогдсон бол;

5.3.3. гадаад ажилтан ажлын байраа дур мэдэн орхисон бол;

5.3.4. хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөр ажил олгогчид шилжиж ажилласан бол;

5.3.5. гадаад ажилтны мэдээллийн санд хуурамч баримт бичгээр бүртгүүлсэн бол;

5.3.6. гэмт хэрэг, зөрчил үйлдэж гэм буруутай болох нь тогтоогдсон бол;

5.3.7. гадаад ажилтан хөдөлмөрийн чадвараа алдсан бол.

5.4. Эрх бүхий байгууллага нь гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон, хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан тухай мэдээллийг гадаадын иргэн, харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

Зургаа. Үйлчилгээний хураамж төлөх, тайлан мэдээ гаргах, хяналт тавих

6.1. Иргэн, хуулийн этгээд энэ журамд заасан үйлчилгээ авахдаа Засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 199 дугаар тогтоолд заасан хувь хэмжээгээр төлнө.

6.2. Эрх бүхий байгууллага үйлчилгээний хураамжийн тайлан мэдээг сар бүр гаргаж, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн болон санхүү, төсвийн асуудал хариусан төрийн захиргааны төв байгууллагад улирал тутам хүргүүлнэ.

6.3. Эрх бүхий байгууллага хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох сунгалт хийх, хасалт хийх үйлчилгээ үзүүлсэн мэдээллийг 7 хоног бүр хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ.